



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Эрхэмлэн ажиллах зарчим батлах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын 3.4, 4.5 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” батлах тухай 406 дугаар тушаал, төвийн Удирдлагын зөвлөлийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 10 -ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус төвийн нийт ажиллагсдын “Эрхэмлэн ажиллах зарчим”-ыг хавсралтаар баталсугай.


2. Дээрх зарчмыг ажиллагсдад таниулан манлайлан ажиллахыг төвийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо /М.Цэрэндэжид/, Байгууллагын соёл, хамтач ажиллагааны баг /Ж.Нармандах/-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү эрхэмлэн ажиллах зарчмыг мөрдөн, хамт олноо манлайлан ажиллахыг төвийн нийт ажиллагсдад уриалсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Н.ЭРДЭНЭБАЯР



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн
1105 дугаар тушаалын хавсралт



ЭРХЭМЛЭН АЖИЛЛАХ ЗАРЧИМ

ЗААВАЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГУРВАН-3

1. ЗӨВЛӨН ХАЛАМЖЛАХ
2. ЗӨВ ХАРИЛЦАА
3. ЗӨВШИЛЦӨЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХОРИГЛОХ ГУРВАН-Х

1. ХЭРҮҮЛ МАРГААН
2. ХОВ ЯРИХ
3. ХЭМЛЭН БУРУУТГАХ

---oOo---